

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр, Мягмар гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-24
<hr/>	
<i>I.Аж үйлдвэрийн сэргэлтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох</i>	3-24

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 40 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: С.Ганбаатар;

Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Г.Ганболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Наранбаатар, Ш.Раднаасэд.

Нэг.Аж үйлдвэрийн сэргэлтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн газрын ахлах мэргэжилтэн О.Уянга, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, мөн газрын шинжээч Ч.Болдбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Отгонбаатар нар байлцав.

Аж үйлдвэрийн сэргэлтийн талаарх мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ж.Батжаргал, Т.Аубакир, Ц.Анандбазар, Д.Батлут нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Д.Батлут, Т.Энхтүвшин нар үг хэлэв.

Аж үйлдвэрийн сэргэлтийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэгийн мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 18 минут үргэлжилж, 18 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Т.ЭНХТҮВШИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 40 минут.

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Т.Энхтүвшин: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэж байна. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Амартүвшин гишүүн ирсэн байна. Аубакир гишүүн ирсэн байна. Батжаргал гишүүн ирсэн байна. Батлут гишүүн ирсэн байна. Дамдинням гишүүн ирсэн байна. Өнөрболор гишүүн ирсэн байна. Туваан гишүүн ирсэн байна. Тэмүүлэн гишүүн ирсэн байна. Цогтгэрэл гишүүн ирсэн байна. Энхтүвшин гишүүн ирсэн байна. Ж.Эрдэнэбат гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанд нийт 57.9%-ийн ирцтэй учир хуралдаан нээснийг мэдэгдэж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Аж үйлдвэрийн сэргэлтийн талаар болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын мэдээллийг сонсох байж байгаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Аж үйлдвэрийн сэргэлт Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын мэдээллийг сонсоно.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг та бүхэндээ

танилцуулъя. Ганхүлэг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн дэд сайд, Дондогдорж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны Хөнгөн үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Ч.Болдбаатар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны Хөнгөн үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, О.Уянга Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын ахлах мэргэжилтэн. Ийм ажлын хэсэг оролцож байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.5-д Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд холбогдох Засгийн газрын гишүүний мэдээлэл, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тайлан, мэдээллийг сонсох эрхтэй гэж заасны дагуу Аж үйлдвэрийн сэргэлтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын мэдээллийг сонсоно. Дэд сайдыг урьж байна. Мэдээллээ 1 номерын микрофон өгөөрэй.

М.Ганхүлэг: Байнгын хорооны дарга, гишүүд та бүхэндээ бас энэ өдрийн мэндийг хүргэе. Сайд бас манай өнөөдрийн хуралд бас танилцуулга хийхээр төлөвлөсөн байсан. Сая мэдээлэл аваад бас шууд яамнаас гараад ирлээ. Бас хоцорч ирсэнд хүлцэл өчье юуны түрүүнд та бүхнээсээ.

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын 1-ээр хөдөө аж ахуйн салбарыг тодорхойлж, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинийг сайжруулж, нэмүү өртөг

шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих, тэр дундаа мах, махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүний экспортын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр зорилт дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийн аж үйлдвэрлэлтийн сэргэлтийн бүлэгт хөнгөн хүнсний үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааг дэмжин 2 зорилтыг дэвшүүлэн, 9 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөн “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулан батлуулсан.

Аж үйлдвэрийн салбарт дэвшүүлсэн бодлогын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотой хууль, дүрэм, журмыг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажлууд хийгдэж байна. Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 онд батлуулсан. Хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг шинэчлэхээр 5 бүлэг 14 зүйл бүхий Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгээд байна.

Өнөөдөр аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгж байгууллагын 80.5% нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүнээс Хөнгөн үйлдвэрлэлийн салбар нь ноос ноолуур, арьс шир, мод, модон тавилга, оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэл, хэвлэл, сав баглаа боодол, дахин боловсруулах, гоо сайхан, ахуйн химийн нийт 3238 аж ахуйн нэгж, үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж байна. 44000 орчим хүн энэхүү салбарт ажиллаж байна.

Хөнгөн үйлдвэрийн салбар нь жилдээ 1.4 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт экспорт 2022 оны жилийн эцсийн байдлаар 507.8 сая ам доллар, нийт импорт 703.2 сая ам доллар болсон байна.

Хөнгөн үйлдвэрийн салбарын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох ноолуурын салбарын экспорт 444.4 сая долларт хүрч, экспортын үнийн дүнг КОВИД-ын өмнөх буюу 2019 онтой харьцуулахад 15.8%-аар өссөн.

2022 оны экспортыг 2021 оны онтой харьцуулахад угаасан ноолуур 6.3%, самнасан ноолуур 102% буюу 2 дахин өссөн байна. Арьс ширний салбарт 25.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 24 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдэж, үйлдвэрлэл 5%-аар өсөж, 18 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн экспортолсон байна.

Хөдөө аж ахуйг 2022 онд дэмжих зээлийг ноолуур бэлтгэл үйлдвэрлэлд зориулж 24 аж ахуй нэгжид 121.9 тэрбум төгрөг, ноос бэлтгэлд 9 аж ахуй нэгжид 13.01 тэрбум төгрөг, арьс шир бэлтгэлд 8 аж ахуй нэгжид 7.1 дэх тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд Засгийн газраас нийт зээлийн хүүгийн 10.65 нэгж хувийн хүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батал баталсан эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд олгосон хөнгөлөлттэй зээлийн үр дүнд ноолуурын салбарын экспорт 2021 онд 332.9 сая ам доллар, 2022 оны байдлаар 444.4 сая долларт хүрч өмнөх онтойгоо харьцуулахад 2021 онд 39%, 2022 онд 33.4%-аар тус тус өссөн байна.

Ноолуур бэлтгэлийн зориулалтаар 500 тэрбум хүртэлх төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг аж ахуйн нэгжүүдэд олгохоор холбогдох Засгийн газрын тогтоолыг Засгийн газрын 2023

оны 2 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар батлуулаад байна.

2023 оны ноолуур бэлтгэлд зориулан олгох зээлийн санхүүжилтийн гэрээг 2023 оны 3 дугаар сарын 9-ний өдөр арилжааны 9 банкттай байгуулсан. Монгол орны бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэхэд мал, амьтны эрүүл мэндийг хамгаалж, тавлаг байдлыг хангах, байгаль орчин, бэлчээр, тэжээл, усны хангамжийг зөв зохистой ашиглах, малын үржүүлэх селекти, тэжээллэг арчилгаа маллагаа зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэхэд тавих зохистой дадлыг нэвтрүүлэх зорилгоор хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагууд MNS-6891 стандартыг боловсруулан баталсан.

Мөн малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарыг мөшгөх зорилгоор хариуцлагатай нүүдэлчин цахим системийг нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлыг хийж байна.

Мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд экспортын Нэг цонхны цахим систем нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Экспортын 1 цонх цахим систем нэвтрүүлсэн мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ олгох, эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлдэг баримт бичгийн давхардалгүй болж цаг хугацааг хэмнэх бүрэн боломж бүрдэнэ.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийн Аж үйлдвэржилтийн сэргэлтийн бүлэгт хөнгөн үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг дэмжин 3.4-т хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэлийг хэмжээг нэмэгдүүлнэ гэж заасан.

Дээрх зорилтыг хангуулах хүрээнд Дархан-Уул, Ховд аймгуудад үйлдвэр, технологийн паркуудыг байгуулах арга хэмжээг төлөвлөн “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулан батлуулсан.

Дархан арьс ширний цогцолбор, Шинэ Ховд аж үйлдвэрийн парк, Дорнод бүсийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркуудыг бүсчлэн байгуулснаар байгаль орчинд ээлтэй, шинэ дэвшилтэт технологи нэвтэрч, арьс ширийг бүрэн боловсруулах боломжийг бүрдүүлнэ.

Үүний үр дүнд мал аж ахуйн гаралтай түүхий эдийн үнэ цэнийг нэмэгдүүлж, малын гаралтай түүхий эдийн үнийг тогтворжуулж, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх юм.

Монгол Улсын Их Хурлаас төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангах замаар Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлэх зээлийн чанарыг сайжруулах хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн болон Монгол Улсын Хөгжлийн банк хооронд салбарын хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайд болон Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн А96 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.

Барилга, хот байгуулалтын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайд нарын баталсан 2023 оны 3 сарын 10-ны өдрийн тушаалаар “Дархан арьс ширний цогцолбор” компаниас Хөгжлийн банкны зээлийн төлбөрт тооцон шилжүүлэхээр санал болгосон нь дуусаагүй гүйцэтгэлтэй дэд бүтцийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн

бодит гүйцэтгэлийг батлагдсан зураг төсөл, төсөвтэй харьцуулан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам, Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурал, Эрчим хүчний үндэсний төв, Барилга хөгжлийн төв, Монгол Улсын Хөгжлийн банк “Дархан арьс ширний цогцолбор” ХХК түүнийг гүйцэтгэгч нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнээрээ Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах дуусаагүй гүйцэтгэлтэй дэд бүтцийн ажил хийгдсэн талбайд 3 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд ажилласан.

Барилга хөгжлийн төв, Эрчим хүчний үндэсний төвийн хамтарсан инженерийн баг “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэсэн аж ахуйн нэгж тус бүртэй хамтран бодит гүйцэтгэлийг батлагдсан зураг төсөл, төсөвтэй харьцуулан хэмжилтийг хийж тайлан гаргах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ажлын хэсгийн дүгнэлтийг талууд эцэслэн хэлэлцэж дуусгахаар ажиллаж байна.

Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн паркийн Ховд аймгийн Жаргалант сумд 100 га газарт байгуулахаар төлөвлөсөн. Нийт 19 үйлдвэр баригдана. 51.8 сая долларын экспорт бий болох тооцоололтой. Дотоодын нийт бүтээгдэхүүн 232 сая доллар, улсын төсөвт 30 орчим тэрбум төгрөгийн татвар хураамж төвлөрүүлэхээр урьдчилсан тооцоо гарсан.

Өдөрт 200 бод, 500 бог төхөөрөх, өдөрт 500 литр сүү боловсруулах, жилд 3000 тонн ноос, 300 тонн ноолуур, жилд 1 сая ширхэг арьс боловсруулах хүчин чадалтай үйлдвэрүүд баригдана.

Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн парк байгуулах дэд бүтцийн ажлуудад

зориулан 19.2 тэрбум төгрөг төлөвлөгдсөн бөгөөд дэд бүтцийн ажлуудыг 2024 онд ашиглалтад оруулна. Өнөөдрийн байдлаар Шинэ Ховд үйлдвэр технологийн паркийн авто замын бүтээн байгуулалтын хөрс хуулалтын ажил эхэлсэн байна.

Зүүн бүсийн тулгуур төв Дорнод аймагт хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд тулгуурлан үйлдвэрлэл технологийн парк байгуулах төлөвлөн ажил ажиллаж байна. Тус цогцолборт дараах үндэс үндсэн чиглэлийн 19 үйлдвэрүүд шинээр байгуулахаар төлөвлөж байна.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.4-т Сэлэнгэ, Хөвсгөл, Дархан-Уул, нийслэлд төрөл бүрийн шахмал хавтан, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээ тусгагдсан.

Тус зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нийслэл, Хөвсгөл, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг мод боловсруулах барилгын модон хийцийн цогцолбор үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, төрөл бүрийн шахмал, модлог хавтан, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, үйлдвэрлэлийг импортын гааль, НӨАТ-ын бодлогоор дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрөөс хөнгөн хүнсний үйлдвэрийн салбарын үйлдвэрүүдийг гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөн дэмжлэг үзүүлж байна.

2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсан гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийн хүрээнд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл 100 хувь хөнгөлөхөөр

тусгагдсан. Дээрх шийдвэрүүд нь үйлдвэр эрхлэгчдэд төрөөс үзүүлэх чухал дэмжлэг болно гэж үзэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Т.Энхтүвшин: Дэд сайддаа баярлалаа. Шинэ сэргэлтийн аж үйлдвэрийн сэргэлтийн талаар Хунс, хөдөө аж ахуйн яамны сайдын мэдээлэлтэй холбогдуулаад асуух гишүүд нэрээ өгнө үү. Цогтгэрэл гишүүнээр тасалъя. Дамдинням гишүүний микрофоныг өгөөрэй.

Г.Дамдинням: Хөдөө аж ахуйн яамны тавьж байгаа мэдээллийг сонслоо. Тэгээд энэ Дархан арьс ширний цогцолборын талаарх танилцуулгыг ингээд харж байна л даа би. Тэгээд энэ түр цахилгаан хангамж дэд өртөө 100 хувьд, Түр худаг цогцолборын түр оффисын барилга 100 хувь, 25 га газрын цэвэрлэгээний ажил 100 хувь гээд, ТЭЗҮ 100 хувь гээд юмнууд нь бол үндсэндээ ингээд нэг их 100 хувиар л харагдаад байгаа байхгүй юу.

Тэгээд энэ ажлыг та нар хэзээ улсад шилжүүлж аваад, хэр хэмжээний мөнгө хэрэгтэй гэж үзэж байгаа юм бэ? Арьс ширний цогцолборыг явуулах нь зайлшгүй шаардлага болчихоод байдаг. Бид нар сая Засгийн газраас арьс ширний цогцолбороо бариагүй байж байж хаачихсан. Арьс ширний экспортыг улс даяар хаачихсан байснаас болоод үнэгүй жалганд хаягддаг байсан юмыг ашигүй сая нэг юм чөлөөлөөд бас арьс шир худалдаж авдаг үнэ нь өсдөг рүүгээ орж байх шиг байна. Малчдад их хэрэгтэй шийдвэр боллоо.

Тэгэхээр энэ арьс ширний цогцолбороо барьж дуустал ер нь бол явах биз бодвол.Тэгээд арьс ширний цогцолборыг одоо байгаа хэсгийг нь аваад цаашаа үргэлжлүүлээд дуусгахад ер нь хэдий хугацаа хэрэгтэй юм гэж үзэж байгаа юм нэгдүгээрт?

Хоёрдугаарт хэр хэмжээний мөнгө орно гэж үзэж байгаа юм танай яам?

Дараачийн асуулт бол энэ малын бүтээгдэхүүн ялангуяа энэ малын экспорт мал, махны экспорт дээр манай эрүүл мэндийн асуудал их яригдаж байна. Малын эрүүл мэндийн асуудал их яригдаж байна. Малын эрүүл мэндийн асуудал дээр энэ олон улсад гаргаад зарах гэхээр манайх бас юу яадаг юм шиг байна тээ, өвчлөл ихтэй гэж. Тэгээд олон улсад нэгдчихсэн гэрээ, конвенцыг нь хараад үзэхтэй зэрэг улсаараа өвчлөлгүй байх ёстой эсвэл бүс нутаг нь өвчлөлгүй байх ёстой.

Гуравдугаарт тухайн нэг аж ахуйн нэгж, ферм өвчлөлгүй байх ёстой юм байна. Манайх бол улсаараа өвчлөлгүй байж чадахгүй, бүс нутгаараа бас өвс өвчлөлгүй байж чадахгүй юм байна л даа. Тэгэхээр энэ тухайн ферм, аж ахуйн нэгж өөр дээрээ ийм бусдаас тусгаарлагдсан орчин үүсгээд, гаргаж болдог юм байна олон улсад.

Тэгээд энэ зохицуулалт ер нь хуульд байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энийг оруулах тал дээр ер нь ямар ажил хийгдэж байна? Мал, амьтны эрх зүйн байдлын тухай хууль билүү, Мал, амьтны тухай хууль билүү? Тэр хууль орж ирэхэд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль тээ? Энэ хууль орж ирэхэд та нар ямар өөрчлөлтүүдийг оруулах гэж байна. Энэ саяын зохицуулалт орох уу? Ийм 3 асуулт. Баярлалаа.

Т.Энхтүвшин: 1 номерын микрофон өгөөрэй, дэд сайд хариулъя.

М.Ганхүлэг: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг гараад бас ажиллаад явж байгаа. Байнгын хорооны бас даргатай бас зөвлөөд хамтарсан нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулаад ажилла, тэгээд хувийн хэвшил болон тал талуудын оролцоог бас ингээд хангаад явъя гээд ийм байдлаар үндсэндээ ярилцсан байгаа.

Тэгээд 3 сард бид бүхэн бас газар дээр нь очиж бас ажилласан. Энэ чиглэлээр ялангуяа бүх талуудыг төрийн өмчит компани гэж нэрлээд байгаа манай талын бас инженер, техникийн ажилчид яг мэргэжлийн байгууллагууд, Барилга хөгжлийн төв, Эрчим хүчний төвийг бас мэргэжлийн бас үнэлгээ хийх газруудыг бүгдийг нь бас авч аваад ингээд очсон байгаа.

Өнөөдрийн байдлаар ажлын хэсгийн дүгнэлтүүдээ эцэслэх энэ шатдаа бас яваад ингээд ажиллаж байна. Ямартай ч саяын энэ таны хэлж байгаа Дархан арьс шир цогцолборын энэ зураг төслийн ажлууд нь үндсэндээ бүгдээрээ хийгдээд дууссан гэдэг тухай ийм слайд мэдээлэл байгаа. Энэ бол 25 га дээрх ийм бас ажил байгаа. Ажлын хэсэг үндсэндээ 25 га дээр байгаа болон 180 га дээр байгаа аль аль энэ ажлуудын дэд бүтцийн асуудлуудыг хурдан явуулах тал дээр санал нэгдсэн байгаа.

Сая үндсэндээ дэд станцын цахилгаан дамжуулах шугам, гадна дулаан, усан хангамж, ариутгах татуургын хос шугам сүлжээний ажил. 10000 мегагийн энэ цэвэрлэх байгууламжийн бас ажил 180 га дээр хийгдсэн байгаа. Дотор дулаан хангамж цэвэр усан хангамжийн шугам сүлжээ, технологийн уур үүсгэгчийн барилга, холбоо дохиолол гэсэн үндсэн 6 ийм дэд бүтцийн ажлыг үндсэндээ бүгдийг нь очиж үзээд тодорхой дүгнэлтүүдийг мэргэжлийн байгууллагууд нь гаргаж ирээд ингээд ажиллаж байгаа.

Тэгэхээр одоо бол хувийн хэвилийнхэнтэй тодорхой үе шаттайгаар энэ дэд бүтцүүдийг шилжүүлэн авах өмнөх төсөвт өртөг, гүйцэтгэгчээс ирүүлсэн төсөвт өртөг, Үндэсний аудитын газрын дүгнэлт гээд 2 жилийн өмнө бас гаргасан дүгнэлт байгаа.

Тэгээд яг энэ ажлын хэсгийн ингээд дүгнэлтийн энэ өөрсдийн гэсэн ингээд тоон дүнтэй болж авч байгаа. Эхний байдлаар та бүхэндээ бас танилцуулахад өмнөх энэ төслөөс нэлээдгүй бас хэмжээнд хэмнэгдэх нэлээн өндөр байдлаар дүгнэсэн нь нотлогдож байгаа.

Тэгэхээр энэ одоо бас тодорхой хэмжээнд бас хэмнэлттэй байдлаар ажлын хэсэг дээр үнийн саналууд гараад саналаа тавина. Хувийн хэвилийнхэн бол одоо энэ дээр албан ёсны хариугаа өгөөд ингээд хэлцлүүд хийгдээд явах. Үндсэндээ суурь бүх ажлууд бэлэн болсон. Ямар нэгэн маргаангүй болсон гэсэн үг. Голдуу яг мэргэжлийн байгууллагын тоотой болж авсан. Энэ тоог гаргахад ямар нэгэн хүмүүс үлдээхгүйгээр аль нэг нь давуу байдал олгохгүйгээр ингээд ажилласан ийм ажлын хэсгийн дүгнэлт бас гаргасан ийм бас сүүлийн үеийн мэдээлэлд бас та бүхэнд байна гэдгийг эхэлье.

Тэгэхээр энэ дүгнэлтүүдийг үндэслээд тодорхой Байнгын хороон дээр бас илүү дэлгэрэнгүй мэдээлүүдийг өгөөд, Засгийн газрын хуралдаанаар бас тодорхой орж шийдэх асуудлууд бас байгаа. Ингээд энэ ажлууд руугаа бас ороод явахад үндсэндээ бэлтгэл ажлууд бэлэн болсон байна гэдгийг та бүхэндээ өнөөдөр бас танилцуулахаар байна.

Малын эрүүл мэндийн асуудал дээр үндсэндээ өнгөрсөн 2022 оны 11 сард Засгийн газрын хуралдаанаар малын хорио цээрийн эрүүл бүс байгуулах энэ тогтоолыг албан ёсоор батлуулж авсан. Тэгээд энэ бас олон улсын нэлээн бас туршилагуудыг судалж үзэж байж хийсэн. Ийм бас шийдэл байгаа. Энэ тодорхой боомт дамнасан захын энэ аймгуудыг түшиглэсэн. Ялангуяа энэ хөдөө аж ахуйн энэ чиглэлийн ялангуяа энэ Ховдын аж үйлдвэрийн парк, Дорнодын энэ паркуудыг түшиглэсэн ийм экспортын чиг баримжаатай ийм бүс нутгуудыг хөгжүүлэх энэ Засгийн газрын тогтоол хэрэгжээд ингээд эхэлсэн байгаа.

Яг Дамдинням гишүүний саяын танилцуулж байгаа аж ахуй нэгжүүдийг хамгаалагдсан аж ахуйн нэгж болох энэ асуудлыг хуулиар зохицуулах энэ чиглэлийн хүсэлтүүд бас манай яаман дээр бас.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Нэмэлт 1 минут өгөөрэй 1 номерын микрофонд.

М.Ганхүлэг: Тэгэхээр энэ хамгаалагдсан аж ахуйн нэгжийг бас байгуулах энэ хуулийн төслийг санаачлах ажил манай яаман дээр бас хийгдээд ингээд бас ажлууд эхэлсэн байгаа гэдгийг бас танд хэлье.

Т.Энхтүвшин: Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Дархан арьс ширний цогцолборын улсад аваад тэгээд цаашаа үргэлжлүүлэх ажил дээр ахиц гараад явж байгаа юм байна гэж ойлголоо. Дараа та бүхэн маань хугацаатай, төсөвтэй танилцуулга өгөөрэй. Ер нь бол жоохон ажил байгааг ойлгож байна. Тэгэхдээ КОВИД-оос өмнөх үеийн хийгээд дуусгачихсан ажил тэр үеийн үнээр хийгдчихсэн учраас нэлээн их цаг хугацаа, мөнгө хэмнэсэн л шийдэл болж байгаа байх гэж бодож байна. Хувийн аж ахуйн нэгжүүдтэйгээ ярьж байгаад.

Тэгэхээр та хэд маань дараа наад хүлээж авах ажлуудаа дуусгасныхаа дараа бид нарт яг Дархан арьс ширний цогцолборыг нийт тэдэн төгрөгөөр энэ түвшин дуусгахаар байна.

Хоёрдугаарт төдий хугацаа орохоор байна гэдэг ийм танилцуулгыг өгөөрэй.

Хоёрдугаарт бол тэр юуны асуудал байна тэр Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиа бас хурдан оруулж ирж энэ өөрчлөлтүүдийг хийвэл манай эдийн засагт бас их хэрэгтэй юм байна лээ шүү. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Дэд сайд Дамдинням гишүүний сая хэлснийг бас анхаараарай.

Ялангуяа энэ Дарханы арьс ширний үйлдвэртэй холбоотой яг тодорхой хариултыг, шийдлийг бас танилцуулаарай. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Шинэ сэргэлтийн бодлого, Аж үйлдвэрийн сэргэлт мэдээлэл орж ирж байна. Мэдээлэлтэй танилцлаа. Хоёр, гурван зүйл байна.

Нэгдүгээрт энэ Хөнгөн үйлдвэрийн тухай хуулиа ер нь яг хэзээ өргөн барих юм бэ? Энэ асуудал яригдаад 3 жил бүтэн болчихож байгаа юм. Одоо хэр нь өргөн баригдаж орж ирдэггүй. Үнэхээрийн л аж үйлдвэржүүлбэ, аж үйлдвэрийн сэргэлтийг хийе гэж байгаа бол дам дамаа тэр нөхөн сэргээгддэг баялаг болсон энэ малын ашиг шим дээр тулгуурласан үйлдвэрүүдийнхээ хөгжлийн асуудлыг бид бодохоос өөр арга байхгүй.

Тэгээд энэ асуудлаа ямархуу байдлаар дэмжих юм, яаж анхаарал хандуулахын энэ тэр гэдэг ер нь бүх асуудал энэ хуулийн үзэл баримтлал, концепцоор л явах болов уу л гэж би хараад байгаа. Тэгэхээр энэ дээр нэг тодорхой хариулт авмаар байна гэж.

Хоёр дахь зүйл. Ноолуурын чиглэлээр биднүүс тогтоол гаргаад, сая Засгийн газар маань тэр БТКУС-дээ өөрчлөлт оруулаад 24 оны 7 сарын 1 хүртэл түр хойшлуулах шиг байна. Гэхдээ бэлтгэж авч байгаа ноолуурын ер нь бид улсынхаа хэмжээнд бүтэн угаагаад самначих хүчин чадал хангалттай бий болсон. Тэгсэн тээ? Одоо бидэнд байж байгаа мэдээллээр тэгж гарч ирээд байгаа.

Тийм учраас хэдийгээр тэр хугацааг нь хойшлууллаа ч гэсэн бид ер нь ажлын байр, энэ иргэдийг ажлын байраар хангаж орлого амьжиргааг нь дэмжье, өөрсдөө бүтээгдэхүүнийхээ боловсруулалтын түвшнийг ахиулж, орж

ирэх орлогоо нэмэгдүүлье л гэж үнэхээрийн л бодож үйлдвэрлэлийн чиглэлээ барьж байгаа бол яам энэ үйлдвэрлэгч нартайгаа дахиж ахиухан уулзаж тэр байж болдог боловсруулалтынх нь түвшинд нь хүргэж, гаргах талаас нь анхаарах ёстой. Энэ нь хаагдчихаагүй нээлттэй байгаа зүйл байхгүй юу. Тэгж байж биднүүсийн энэ яриад байгаа зорилт явна гэж.

Дараагийн нэг том зүйл энэ ноосны асуудал. Бид жилдээ нэг 32000 тонн ноос бэлтгэх тийм боломж байх шиг байна. Тэр тусмаа тэр бүдүүн ноосыг угаагаад, самнаад тэр ноосноос хялгасгүй ноолуур шиг зүйл гаргаж аваад байгаа зүйл байгаа юм. Үүнийг ер нь жоохон анхаарал хандуулж, боловсруулалтын түвшнийг нь ахиулж гаргах юм бол Монголын ноосны үнэ цэн өсөх бололцоо байгаад байгаа. Энэ дэлхийн бүс материал үйлдвэрлэдэг гэдэг юм уу энэ бэлэн хувцас хийдэг тэр тусмаа ноосон дээр тулгуурлаж хийгддэг энэ улс орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр нэлээн сайн анхаарч ажилламаар байна. Ганц компани зайлуул өөрийнхөө чадлын хэмжээнд зүтгээд баралгүй тэнд сөхөрснийг биднүүс сая өөрсдөө очиж харцгаасан.

Тэгэхээр энэ ганц нэг аж ахуйн санаачилга дээр үүнийг үүрүүлнэ гэж байхгүй Төр бодлогоо энэ рүү чиглүүлж явах ёстой.

Тийм учраас энэ ноосны талаар ер нь төрийн бодлого яаж гарах юм, яаж явах юм, яаж энийг үнэ цэн оруулж байж байгаа энэ түүхий эдийг баялаг болгож нэмүү өртөг шингээж гаргах ийм бололцоо боломж бидэнд байгаа юм бэ? Энэ талаарх төсөөллийг нэг сонсмоор байна гэж.

Арьс ширний цогцолборын тухай бид их олон ярьсан. Зураг, төсөв, шийдэл гээд үндсэндээ ер нь 3, 4 жил явчих шиг боллоо. Тэгээд ч учраа олж чадаж байгаа юм уу, үгүй юм уу их зовлонтой байна.

Тэгвэл арьс ширийг боловсруулаад байгаа тэр битгий хэл эцсийн бүтээгдэхүүн.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүнд 1 минут нэмээд өгөөрэй.

Ж.Батжаргал: Эцсийн бүтээгдэхүүн хийгээд байгаа энэ үйлдвэрүүд дээрээ суурилж явбал яасан юм бэ? Хэн авч явах менежмент нь байхгүй нэг хөндий юм яриад байсан дор бол тэр ерөөсөө цаг хугацаа, хөрөнгө санхүү, оюун санаа, тэр технологи бүх юм руу байдаг юмаа зарцуулчихсан энэ улсуудынхаа бодит чадамжийг ашиглах, тэднүүсийгээ дэмжих, өргөтгөх тал дээр ер нь юу бодоод байгаа юм бэ? Би одоо бэлэн энэ л чадамж дээрээ тулгуурламаар санагдаад байх юм. Тэгж байж энэ яриад байгаа асуудал чинь бүтэн шийдэгддэггүй юм гэхэд ямар ч байсан тодорхой хэсэг нь бүрэн шийдэгдэх ёстой. Манайхан баахан гутал хийж байна, юм хийж байна л гэнэ. Яг нарийндаа хэрэглэж байгаа материал нь үндэсний үйлдвэрийн боловсруулалт юм уу, гаднын импортын бэлдэц юм уу гэдэг асуудал байгаад байна шүү дээ. Энийгээ хүртэл ангилж.../минут дуусав./

Т.Энхтүвшин: 1 номерын микрофон. Дэд сайд.

М.Ганхүлэг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хөнгөн үйлдвэрийн тухай хуулийн асуудлыг хэлэлцэж яг одоо хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэрийнхээ энэ хуультай нийлүүлж явах уу, тус тусдаа хууль явах уу гэдэг энэ асуудлыг Аж үйлдвэрлэлтийн үндэсний хорооны бүрэлдэхүүн батлагдаад ингээд бас ажлууд эхлэхээр болсон байгаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон бусад Засгийн газрын гишүүд, мэргэжлийн бас байгууллагууд, Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэрлэгчдийн бодлогын байнгын хорооны дарга бас энэ бүрэлдэхүүнд орохоор үндсэндээ нэрс нь гараад ингээд батлагдсан байгаа.

Тэгэхээр энэ Аж үйлдвэрийн үндэсний хороонд үндсэндээ энэ асуудлыг уламжлаад бид бүхэн бас бэлтгэл ажлуудыг хангаад явж байна. Тэр хороон дээрээс яг илүү нарийн аль аль байдлаар хуулийн төслүүдээ өргөн барих вэ гэдэг асуудлуудаа хэлэлцээд явахаар ажиллаж байна.

Ноолуурын зохицуулалттай холбогдолтой, бүрэн хүчин чадалтай холбогдолтой ноос самнах болон арьс ширний яг одоогийн байгаа үйлдвэрлэлүүдийг нэмэгдүүлэх гэдэг бас зөв асуултыг тавьж байна. Тэгээд энэ чиглэлээр манай газрын дарга Дондогдорж дарга бас нарийн мэдээллийг өгнө.

Т.Энхтүвшин: 2 номерын микрофон.

М.Дондогдорж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлого хэрэгжүүлэх зохицуулах газрын дарга Дондогдорж. Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Ноолуур, арьс шир, ноосны салбарыг хөгжүүлэх хүрээнд эхний ээлжид 2022 онд хөнгөлөлттэй зээлийг гаргасан байгаа. Энэ бол 3%-ийн хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээлийг гаргасан байгаа. Үүний үр дүнд ноолуур боловсруулах салбарт 24 аж ахуйн нэгж, 121 тэрбум, арьс ширний салбарт 8 аж ахуйн нэгж, 7.1 тэрбум төгрөг, ноосны салбарт 9 аж ахуйн нэгж, 13 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байгаа. Энэ бол 2 жилийн хугацаатай яг үйлдвэрийг түүхий эдээ бэлтгэхэд зориулж олгосон ийм зээл байж байгаа.

Үүний үр дүнд түрүүн дэд сайдын мэдээлэлд орсон үйлдвэрлэлийн хэмжээ өссөн, экспортын хэмжээ өссөн байгаа. 2023 онд бид нар сая Батжаргал гишүүний хэлсэнчлэн энэ ноолуурын салбарыг өргөжүүлэх, хүчин чадлыг

нэмэгдүүлэх, ашиглалтыг бүрэн ашиглах хүрээнд 500 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг, үйлдвэр 5%-ийг хариуцах Засгийн газраас 13%-ийг хариуцах, нийтдээ 18%-ийн хөнгөлөлттэй зээлийг гаргаад, 9 банкттай гэрээ байгуулсан.

Өнөөдрийн байдлаар “Хаан” банкин дээр 6 үйлдвэрт 30 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгоод, 2 аж ахуйн нэгжид 3.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох ийм шийдвэр гараад явж байна. “Голомт”, “Хас” банкнууд дээр мөн зээлийн асуудлууд шийдэгдээ явж байна.

Ноосны салбарт бид нар бас өнгөрсөн 7 хоногт Батжаргал гишүүний хамт Монгол ноос дээр очиж ажилласан. Өнгөрсөн хугацаанд бол Монгол ноосны хувьд бас тодорхой асуудлууд яамтай нөгөө өмнөх өр авлагын ажил, асуудал байсан учраас үйлдвэр зогсонги байдалд байсан. Энийг бас бид нар цаашидаа үргэлжлүүлэх ноосны салбарт энэ ноосноос хялгас ялгаад ийм нарийн хонины ноос гаргаж байгаа энэ үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бас энэ өмнөх асуудлыг шийдэхээр холбогдох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар зэрэг холбогдох газруудтай ингээд хамтраад ажиллаад явж байна.

Арьс ширний цогцолборын хувьд гэх юм бол Дархан дахь ажил түрүүнд танилцуулсан байгаа дэд сайд. Тэгэхээр бид нар цаашидаа энэ Дархан дахь ажил, арьс ширний цогцолборыг дуусгах, Ховдын цогцолборыг дуусгах ажлууд байж байгаа. Өнөөдрийн хувьд гэх юм бол арьс ширний салбарт түүхийгээр вэт билүү хэлбэрээр одоо бэлтгэж байгаа. Жилд 17 саяас гарч байгаа арьсыг бүрэн боловсруулах хүчин чадалд бүрэн суурилагдсан байгаа.

Харин эцсийн бүтээгдэхүүн бэлэн арьс боловсруулах хүчин чадал хараахан бүрэн гүйцэд суурилдаагүй байгаа учраас энэ Дархан, Ховдод энэ бүрэн гүйцэд

боловсруулах арьсны үйлдвэрийг цогцолборыг байгуулахаар ажиллаж байна.

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тиймээ байдлуудыг хэдүүлээ тал бүрээсээ бүгд мэдэж байгаа. Тэгээд энд нэг л тийм л зүйл байгаад байна л даа. Бид бэлэн ноосыг ямар шат дамжлагаар, яаж боловсруулаад, ямар хэмжээний юм гаргаж болдог вэ гэдгийг 1 аж ахуйн байгууллага нүдэн дээр чинь асраад гарт чинь бариулчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг энэ загвараар гэдэг юм уу, техник технологийг нь илүү нарийсгаж, шинэчлээд яаж ноосоо хэдүүлээ үнэ цэнд оруулах юм гэдэг Монголын ноосны бодлого байна уу л гэж асууж байгаа юм. Тэрнээс тэр үйлдвэр өр төлбөрийнхөө асуудлыг шийдсэн үү, шийдээгүйн тухай асуудал биш. Ерөөсөө бид тийм л юм ярьж байгаа байхгүй юу. Монголын ноосыг яах юм бэ хэдүүлээ? Яаж үнэ цэнд оруулах юм гэдэг л юм ярьцааж байгаа улс шүү дээ.

Тийм учраас цаана чинь нэг хэсэг улсууд өөрийнхөө хөрөнгө, мөнгөөр эрсдэл хүлээгээд ингэж болдог юм байна гэдгийг чинь нүдэн дээр чинь харуулаад, гарт чинь бариулчихлаа. Одоо тэгвэл энийг хэдүүлээ яаж.../минут дуусав./

Т.Энхтүвшин: 2 номерын микрофон. Асуусан асуултад бас тодорхой оновчтой хариулаад явчих.

М.Дондогдорж: Ноосны салбарт бид нар бас инновацыг нэвтрүүлж, энэ зорилгоор бас шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилгоор энэ өнгөрсөн хугацаанд хөнгөлөлттэй зээлүүдийг олгосон гэдгээс энэ дээр бол ноосон бордооны үйлдвэрт бас хөнгөлөлттэй зээл олгоод “Монпеллетс” гээд үйлдвэр ноосон бордоо үйлдвэрлээд явж байна. “Эко ноос” гээд компанийн хувьд бас барилгын,

дулаалгын материал үйлдвэрлээд явж байна. Энэ мөн түүнчлэн ноосоор “Янмал” гээд компаниуд зээл аваад ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэх энэ үйл ажиллагаануудын хэрэгжээд явж байгаа.

Тэгэхээр бид нар зөвхөн ноосыг өмнө уламжлалт эсгий хивснээс гадна инновац шингэсэн энэ шинэ бүтээгдэхүүн гаргах чиглэл дээр ажиллаад явж байгаа.

Т.Энхтүвшин: Батжаргал гишүүнд 1 минут нэмээд өгөөрэй.

Ж.Батжаргал: Тэгэхээр үүн дээр бид ямар бодлого гаргах юм бэ л гэж асуугаад байна шүү дээ.

Т.Энхтүвшин: Нэмээд хариулах юм уу? Дондогдорж дарга саяын асуултад. Дараа нь тэгвэл та хэд энэ Батжаргал гишүүний асуусан асуултад бас бичгээр хариу өгөөрэй.

Аубакир гишүүн.

Т.Аубакир: Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд аж үйлдвэржилтийн сэргэлтийн талаар гээд Монгол Улсын Засгийн газраас бас оновчтой санал, санаачилга дэвшүүлээд ажиллаад явж байгаа. Энэ хүрээнд маш олон ажлууд бий. Надад хоёрхон асуулт байна.

Нэгдүгээрт дэд сайд өөрөө ахлаад энэ мал, махны экспорттой холбоотой шийдлүүдийг гаргах хүрээнд энэ аж ахуйн нэгжүүдийн цаг хожих, экспортыг нэмэгдүүлэх хүрээнд энэ Нэг цонхны үйлчилгээтэй болгоё гээд дэд сайд та өөрөө ахлаад явж байгаа. Энэ Нэг цонхны үйлчилгээ маань яг ямар түвшинд байна вэ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт маань энэ түрүүн Дамдинням гишүүн бас асууж байсан. Энэ Дарханы арьс ширний цогцолборын энэ дээр танай гаргаж өгсөн мэдээлэл байна л даа. Шинэ сэргэлтийн бодлого, Аж үйлдвэрийн сэргэлт Хөдөө аж ахуйн яам. Энэ дээр тэгээд төслийн

явц 100 хувь, түр цахилгаан хангамж, дэд өртөө, түр худаг, цогцолборын түр оффисын барилга 100 хувь, 25 га газрын цэвэрлэгээний ажил ТЭЗҮ 100 гээд. Энэ яг Дархан дээр 2 арьс ширний цогцолбор явж байгаа гэж бид ойлгож байгаа. Нэг нь хувийн хэвшлийн хийгээд эхлүүлчихсэн Хөгжлийн банктэй холбоотой асуудал.

Нөгөөдөх нь Италийн билүү Польшийн нэг зээлээр явах ёстой байсан Хүнс, хөдөө аж ахуйн яамны хариуцаад явж байгаа төсөл байгаа. Энэ гүйцэтгэл нь яг алиных нь вэ? Бид нар манай Байнгын хороо очиж ажилласан. Сүүлд харах нь дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг бас очиж ажиллаад, энэ дээр байна л даа. Холбогдох шийдвэрүүдийг нь гаргахын хүрээнд ажлын хэсэг байгуулагдаад яг газар дээр нь очоод, танилцаад, ажиллаад явж байгаа харагдсан. Бидний баримталж байгаа гол зарчим бол төр нь хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд хувийн хэвшлийнхний хийж болох ажилд нь төрийн мөнгөөр гадна, дотноос зээл аваад, хийгээд өрсөлдөхөө больё л гэсэн алтан зарчим л байгаа.

Энэ зарчмаа бариад явж байгаа юу? Нөгөө хувийн хэвшлийнхний хийж байгаа Хөгжлийн банкнаас өр зээл тавин барин, хэл ам болон барин авсан нөгөө хувийн хэвшлийнхнийгээ нугаслаад хаячихсан уу эсвэл? Төрийн нөгөө гаднаас авах зээлээр хийх дээрээ шийдвэрээ тогтсон уу? Үгүй бол тэр хувийн хэвшлийнхнийгээ дэмжээд Хөгжлийн банкных нь асуудлуудыг нь төрөөс янз бүрээр зохицуулаад явахаар шийдсэн үү? Эцсийн дүндээ Монгол Улс арьс ширний үйлдвэртэй болох нь л нэгдүгээр зорилго гэсэн ийм 2 асуулт байна.

Нэгдүгээрт нөгөө Нэг цонхны үйлчилгээ.

Хоёрдугаарт яг энэ 100 хувийн гүйцэтгэлтэй гээд байгаа чинь хувийн хэвшлийнх нь гүйцэтгэл үү? Эсвэл нөгөө төрийн гэж байгаа төслийнх нь гүйцэтгэл үү гэсэн 2 асуулт байна.

Т.Энхтүвшин: 1 номерын микрофон, дэд сайд.

М.Ганхүлэг: Аубакир гишүүний асуултад хариулъя. Мал, махны юу экспортын дүнг та бүхэн бас мэдээлэл авсан байгаа болов уу гэж бодож байна. Өнгөрсөн 2022 оны нийт дүнгээс 2023 оны эхний 3 сарын дүн одоо бас нэмэгдсэн ийм бас эерэг үзүүлэлттэй бас байгаа. Тэгээд энэ бас сүүлийн хагас жилийн хугацаанд тодорхой бас арга хэмжээ авч ажиллаж байгаа бас зөв бодлого, шийдвэрүүдийн бас үр дүн КОВИД-ын дараах бас хорио цээр бас тавигдсантай холбогдолтой ийм эерэг үр дүнгүүд гарч байгаа.

Цааидаа нөгөө махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой квотуудыг бас үндсэндээ цуцалсан. Энэ байдлаа хадгалаад ингээд ажиллаад явна. Яг нөгөө нэг олон улсын мал эмнэлгийн тэр байгууллагын стандартад нийцсэн аж ахуйн нэгжүүдийн тоогоо нэмэгдүүлэх энэ чиглэлийн мэдээллүүдийг өгөх чиглэлээр бас нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байгаа.

Энэ байгууллагуудын хамгийн том асуудал нь үндсэндээ зөвшөөрлөө авах энэ процессын асуудал байсан. Тэгээд энэ процессын асуудал бол үндсэндээ 14-өөс бараг сарын хугацаанд үргэлжилдэг. 6, 7 байгууллага дамждаг энэ байдлыг халах зорилготой цахим системийн ажил маань хийгдээд дууссан. Одоо дууссан байгаа гэдгээ хэлье. Болсон гэсэн үг.

Албан ёсны нээлттэй E-business гэдэг энэ цонхоор дамжуулаад 4 сарын 6-нд нээлтээ хийхээр юм байна лээ. Энэнтэй уялдуулж хамт нэг нэршилтэйгээр явуулахаар бид бүхэн Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай бас хамтран ажиллахаар болоод ингээд ажиллаж байна.

Ямар ч байсан 3 сарын хугацаанд 6 байгууллагын бүх цахим системийг 1 дор нэгтгэх энэ ажлаа хийгээд одоо ингээд

дууссан байгаа гэдгийг хэлье. Албан ёсны нээлтийн арга хэмжээг бас олон нийтэд бас танилцуулах болно.

Хоёр дахь асуудал бол энэ асуудал бол үндсэндээ бас сүүлийн нэлээн олон жил бас яригдаад ялангуяа нөгөө Хөгжлийн банктэй холбогдолтой, өр төлбөртэй холбогдолтой бас ийм асуудлаас гол асуудал нь бас болоод байгаа. Бас хэд хэдэн дүнгүүдтэй байгаад байсан асуудал ямартай ч нэг дүнтэй болж хувирч байгаа. Яг Хүнс, хөдөө аж ахуйн яамны зүгээс энэ боловсруулах үйлдвэрүүдтэй холбогдолтой энэ ажлууд дээр тантай яг байр суурь нэг байгаа гэдгийг хэлье.

Энэ нь одоо зөвхөн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг төр хийнэ гэдэг дээрээ байгаа. Яг тэр дэд бүтцийг ашиглаад үйлдвэр бүтээн байгуулалтын ажлуудаа хэрэгжүүлэх энэ ажлыг нээлттэй сонгон шалгаруулалтаар хувийн хэвшлийн байгууллагуудад үндсэндээ олгохоор, үндсэндээ тогтоод ажиллаж байгаа гэж та ойлгож болно.

Таны саяын дурдсан энэ 25 га дээрх төлөвлөлтийн ажлуудын ТЭЗҮ-гийн энэ зураг төсөлтэй холбогдолтой энэ мэдээллийг энэ дээр ингэж оруулсан байна. Цаашиаад аль алиных нь дэд бүтцийн ажлуудыг үндсэндээ төр хийж, хэрэгжүүлж дуусгаад, зарим тохиолдолд аль алин дээр нь арьс ширний үйлдвэр гэхгүйгээр хөдөө аж ахуйн чиглэлийн бас бусад төрлийн үйлдвэрлэлүүдийг нэгдсэн байдлаар парк байдлаар оруулж ирээд ингээд өргөжүүлээд явах бүрэн боломжууд байна гэдэг ийм байдлаар ажлын хэсэг дүгнэлтээ бас бид бүхэн бас гаргаж байна.

Тэгэхээр заавал 25, 180 гэхгүйгээр энэ төслүүдийг ер нь нийлүүлээд илүү үе шаттайгаар, эхний ээлжид цуврал байдлаар ингээд явуулах энэ ажлуудыг үндсэндээ төлөвлөөд явна. Энэ ажлуудыг хувийн хэвшил хийнэ. Төр зөвхөн энэ 180-ын га хүртэлх одоо хийгдсэн байгаа тэр 5

дэд бүтцийн ажлын эхний удаад 2-ыг нь авахад, одоо дуусгахад боломжтой байна гэдэг дүгнэлтүүд гарч байна.

Тэгэхээр тэр 2 ажлынхаа дүгнэлтийг эхлүүлээд явъя. Үлдсэн нь бас дахиад нарийн лабораторийн шинжилгээнүүд оруулах, мөн мөнгөний, санхүүгийн боломжийн хувьд асуудлууд бас байгаа. Ийм бас үр дүнгүүд байгаа.

Т.Энхтүвшин: Тодруулъя. Аубакир гишүүнд микрофон өгөөрэй.

Т.Аубакир: Баярлалаа. Тэгээд энэ өнгөрсөн 2022 оны 10 сарын 21-ний өдөр Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргасан тогтоолын хүрээнд үндсэндээ Мал, махны экспортыг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулагдаад ажилласан. Энэ хүрээнд бас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу үндсэндээ манай Монгол Улс маань мал, махны экспорт дээр Нэг цонхны үйлчилгээтэй 7 төрлийн байгууллагын 40 гаруй төрлийн бичиг баримтыг үндсэндээ 40 гаруй хоног энэ түгжрэн дотор явж хөөцөлддөг байсан бол Нэг цонхон дээр 90 цаг гэж байгаа билүү 72 цаг билүү дотор үндсэндээ экспортын зөвшөөрөл авч болдог болсон бас давуу тал бий болж байгаа юм.

Мөн 11 сард гарсан Засгийн газрын тогтоолын хүрээнд хонь, ямаа, адууг квотгүй болгосон. Үхэр дээр тодорхой хэмжээний сүргийн бүтэцтэй холбоотой квотууд зайлиггүй бодлого бариад явах ёстой. Энэ дээр квоттой байх нь зөв гэж. Тийм учраас хувийн хэвشلүүд маань гаднах улсын түнш байгууллагуудаа олоод, хүлээн авагч улсын буюу импортлогч улсын тавьж байгаа.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Цогтгэрэл гишүүн байхгүй байна. Анандбазар гишүүн. Анандбазар гишүүний микрофоныг өгөөрэй.

Ц.Анандбазар: Баярлалаа. Хөдөө аж ахуй бол одоо их чухал салба. Энэ

чухал салбарт 4 жилд ахиц гаргаж ажиллах нь та бүхний хамгийн чухал үүрэг гэж би бодож байгаа. Ноднин жил Үйлдвэржилтийн байнгын хорооны Хөнгөн үйлдвэрийн дэд хорооноос ажлын хэсэг гараад Монгол Улсын 4 аймгаар явж сүү, сүүн бүтээгдэхүүн хангамж, тэрний үнэ үнэлгээ, нийлүүлэлт дээр бодлогын том тогтоол гаргаж хэрэгжилт энэ жилээс эхлэх ёстой. Шинээр хийх юмаас гадна хийсэн юмаа бодитой болгох их чухал байна.

Тийм учраас та бүхнээс би тогтоолын төслийн хэрэгжилтийн тухай тодорхой асуулт асуух гэж байна. Та бүхэн санаж байгаа бол 2022 оны 6 сарын 15-ны 7 тоот Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол гарч, чиглэл өгсөн байгаа. Энэ 7 тоот тогтоол та бүхэнд хүрсэн байх гэж бодож байна.

Эндээс хамгийн чухал 2 хэсэг байгаа. Энэ Туваан гишүүний ахалсан ажлын хэсэг одоо 300 километрийн радиуст Монгол Улсын сүү, сүүн бүтээгдэхүүнийг сүүний одоо байгаа үйлдвэрүүдэд нийлүүлэх, зөвхөн суурин буюу фермерийн аж ахуйгаас сүү авахаас гадна бэлчээрийн мал аж ахуйгаас сүү авч малчин ардын хөдөлмөрийг нэмэгдүүлэх ийм бодлогын чанартай шийдвэр гарсан.

Энэний хамгийн том хөшүүрэг бол өвөл, зуны татаас буюу сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлдэг аж ахуйн нэгж, хувь хүнд өвөл олгодог байсан 500 төгрөгийн урамшууллыг зуны туршид оруулахаар тусгасан байгаа. Энэ тогтоол хүргэгдсэн гэж бодож байна.

Энэ дээр та бүхнээс энэ 4 дүгээр заалт. Сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх, боловсруулах, үйлдвэрлэх, борлуулах, тээвэрлэхэд онцгой анхаарч, нийслэл, орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон төсөвт байгууллагуудын тохирлын баталгаатай, эрүүл, аюулгүй сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах, үйлдвэрлэгчдийг төрийн худалдан авалт, даатгалын сангийн зохицуулалтаар дэмжлэг ажлыг

зохион байгуулах гэсэн ийм 1 асуулт байгаа. Ямар ажил хийж байна маш тодорхой хариулна уу?

Хоёрдугаарт, Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх. Зуны улиралд сүүний илүүдэлтэй аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх. Импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацааг урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх.

Малын малын эрүүл мэндийн гэрчилгээ, бүртгэл мэдээллийн сан, цахим систем баталгаажуулан бүтээгдэхүүн мэдээлэл болон татварын цахим баримтын системийг боловсронгуй болгож, байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах. Үүний үндсэн дээр малчин ардуудаас авсан сүүг, сүүн бүтээгдэхүүн 500 төгрөгийн урамшууллыг өвөл, зуны туршид олгож байхаар шийдсэн.

300 километрийн радиус дотор Төв аймгийн 27 сум тэр чигтээ, Хэнтий аймгийн 8 сум, Дорноговь аймгийн арын 7 сум, Говьсүмбэрийн 7 сум, Говьсүмбэр аймгийн 3 сум, Дундговийн арын бүсийн 8 сум, Булган аймгийн урд 8 сум, Сэлэнгийн урд талын 8 сум нийт 40 гаруй сумын малчин өрхүүд хамрагдахаар байгаа.

Энэ тогтоолын төслийн биелэлтийг дэд сайд хариулна уу. Энэ их чухал тогтоол болсон байгаа. Ер нь аливаа ажлыг хийхдээ нэг нэгээр нь гараасаа гаргаж, бодитой явах юм бол та бүхэн энэ хүнс, хөдөө аж ахуйн гаралтай, малын гаралтай түүхий эдийг үнэтэй болгоход бодитой хувь нэмэр орно.

Хоёрдугаарт Байнгын хороон даргад албан ёсны нэг ажлын хэсэг байгуулах тухай мэдээлж байгаа. Тэр бол

түрүүн Батжаргал гишүүний асуусан асуулт байгаа. Хонины ноосыг яаж өндөр болох вэ гээд. Энэ дээр бид.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Анандбазар гишүүнд 1 минут нэмж өгье.

Ц.Анандбазар: Энэ хонины ноосыг боловсруулах тал дээр Англи болоод Энэтхэгийн туршилагыг судалж байгаа. Энэ дээр ажлын хэсэг байгуулж, манай дэд хорооноос ажиллахаар шийдвэрлэсэн. ТЭЗҮ-г аймгийн Засаг даргын дэргэдэх нөөц, мөн Эдийн засгийн сайд Хүрэлбаатараас тодорхой дэмжлэг, туслалцаа аваад боловсруулаад энэ асуудлыг шийдэх гэж байгаа.

Ер нь яамны хэмжээнд шийдэхэд бас томдсон асуудлууд их байдаг. Тэгээд бид бол одоо юуг хамтарч хийх вэ, юуг Байнгын хороо оролцож хийх вэ гэдгээ бас ялгах ёстой юм байгаа юм. Ийм 2 том бодлогын асуудал байгаа. Ер нь энэ 4 жилд миний тавьж байгаа зорилго, манай Дэд хорооны тавьж байгаа зорилго сүү, сүүн бүтээгдэхүүнийг үнэтэй болгоно. Малчдаас сүү авдаг болгоно. Дээр нь энэ хонины ноосыг боловсруулдаг болгоно. Одоо энэ цаасан дээр тавьсан биш жинхэнэ утгаар нь шийдэх гэж байгаа. Тэгэхээр энэ заалтынхаа албан ёсны хариуг авъя.

Т.Энхтүвшин: Дэд сайд 1 номерын микрофон өгөөрэй.

М.Ганхүлэг: Анандбазар гишүүний асуултад хариулъя. Нэмэлт саналууд байвал Довчинсүрэн дарга бэлдэж байгаарай. Тодорхой яг Байнгын хорооны 2022 оны 6 сарын 15-ны 07 дугаар тогтоолтой холбогдолтой асуулыг бас асуулаа.

Үүний хүрээнд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудад олгосон тодорхой хөнгөлөлттэй зээлүүд болон сүүний урамшуулуудыг бас олгох

байдлаар энэ салбарыг бас дэмжих гол ажлууд явагдаж байна.

2022 оны байдлаар 6 тэрбум төгрөг үндсэндээ батлагдсан. Үүнээс 5.6 тэрбумын гүйцэтгэл гарч, нийтдээ сүү боловсруулах 12 үйлдвэрт 2021 оны 12 сар, 2022 оны 1, 2, 3, 11 дүгээр сард болохоор 11 сая 300 мянган литр сүү бэлтгэн нийлүүлсэн. 8795 малчинд энэхүү урамшууллыг үндсэндээ олгосон байна.

Түүхий шингэн сүүний литр тутамд 500 төгрөгөөр бодож энэхүү урамшууллыг олгосон. Давхардсан тоогоор 8755 малчин, 40 эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч нар гэдэг ийм бас тооцоолол байна.

Ноосны урамшууллын хувьд 2021 онд 31 тэрбум төгрөгийг ойролцоогоор 31.9 тэрбумыг төсөвлөсөн. Үүнээс 30.9 тэрбумын гүйцэтгэлтэй. Хонины ноосыг килограмм тутамд 1500 төгрөгөөр, тэмээний ноосыг 2000 төгрөгөөр үндсэндээ урамшуулал бодож олгосон байгаа. Үндэсний боловсруулах үйлдвэр 2021 онд 2.1 мянган тонн хонь, тэмээний ноос бэлтгэн нийлүүлсэн.

Малчин, малчин бүхий этгээдэд олгосон мөнгөн урамшууллын нийт дүн байна. Ойролцоогоор 90650 малчин үндсэндээ 7 малтай хоршоонд энэхүү урамшууллыг олгосон байна.

2023 оны хувьд Хүнсний хувьсгалын хүрээнд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх энэ чиглэлээр үндсэндээ зээлийн дэмжлэгийг үндсэндээ олгохоор болсон байгаа. Хүнс, хөдөө аж ахуйн яам болон 10 банкттай хамтарч энэхүү зээлийг үндсэндээ олгоно. Ойролцоогоор 13 орчим нэгжтэй тэнцэх хувийн хүүгийн дэмжлэгийг үзүүлнэ. Энэ нийт дүнгээрээ 1 их наяд орчим зээлийг энэ хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр гаргаж байгаа. Энэ дотор сүү, сүүн бүтээгдэхүүн бас голлох ийм байр суурьтай орж байгаа орж байгаа. Яг сүү, сүүн бүтээгдэхүүн дээр 45 тэрбум

төгрөгийн зээлийг үндсэндээ 2023 онд нэмэгдүүлж олгохоор тооцсон байгаа.

Т.Энхтүвшин: Анандбазар гишүүн тодруулъя.

Ц.Анандбазар: Түрүүнд би хэллээ шүү дээ. Сүүг юу гэж ойлгодог байсан гэхээр социализмын үеэс 130 километр байрлаж байгаа фермерийн аж ахуйгаас сүү авдаг гэж ойлгодог байсан. Ер нь танай яамны ч бодлого тэр фермерийн сүү омега 3 гэж ийм витамин нь алга болчихсон, өөрөөр хэлбэл чанарын түвшин нь хүрдэггүй ийм сүү байдаг. Бэлчээрийн мал аж ахуйн сүү омега 3 гээд том хүмүүс бол аптекаас нэмж худалдаж авдаг ийм сүүтэй. Хүүхдийн шүд цоордоггүй ийм онцгой сүү байдаг юм.

Тэгээд манай ажлын хэсэг юу шийдсэн гэхээр 300 километрийн радиуст байгаа нийт малчин өрхүүдээс зөвхөн фермерүүд биш сүүг худалдаж авах тэр дундаа литр тутамд 500 төгрөгийн урамшууллыг өвөл, зунгүй олгуулахаар тогтоолын төсөл хийсэн. Хяналтад манай Дэд хороо миний бие тавихаар ийм чиг.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Нэмээд 1 минут өгье Анандбазар гишүүнд.

Ц.Анандбазар: Тэгэхээр надад танай яаман дээр тавигдсан энэ урамшууллын үнийн дүн хэрэгтэй байна. Одоо бид Хүрэлбаатар сайдтай сумуудаас татан авах сав, тоног төхөөрөмжийн асуудал ярьж байгаа. Энэ тавигдаад эхлэнгүүт сумуудаас сүү авч эхэлнэ. Сүү авахад тухайн үйлдвэрлэж байгаа компани нь 600 төгрөг өгнө, улсын урамшуулалд 500 төгрөг ингээд 1100 төгрөгөөр малчин ардын гар дээрээс сүү авах ёстой юм. Энэ бараг хувьсгал болохоор ийм том юм болж байгаа. Одоо үнээгээ ирэхлээр нь явуулдаг ийм заншил бий болчихоод байна шүү дээ. Үнээ саадаг хүн байхгүй болчихоод байна.

Тэгэхээр энэ асуудлыг яг тодорхой тоотой асуумаар байна. Хэрвээ бэлэн биш бол сайдын зөвлөл дээрээ хуралдаад энэ жилийнхээ төсөв дээр хэдэн төгрөг тавьж байгаагаа надад ирүүлэх хэрэгтэй байна.

Хоёрдугаарт энэ заалт 43 тэрбум дээр яг юу юу нь, яаж зээл авах боломжтойгоор очиж байгаа вэ? Одоо энэ зээлийг хаанаас олгох вэ? Энэ зээлийг хэн хариуцаж байгаа вэ, энэ төсөв дээр байгаа юу гэдгийг бас тодорхой хариулах хэрэгтэй.

Т.Энхтүвшин: Дэд сайд 1 номер.

М.Ганхүлэг: Тэр яг 300 километр радиотой гэдэг дээр дарга бэлдэж байгаарай. Би зээлтэй холбогдолтой мэдээллийг өгье.

2023 онд 44.5 тэрбум төгрөгийг үндсэндээ улсын төсөвт сүү, сүүн бүтээгдэхүүнтэй холбогдолтой энэ урамшуулал дээр үндсэндээ тавьсан байгаа. Тэгэхээр цаашидаа үндсэндээ энэ 2023 онд яг сүүний урамшуулал 4 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байгаа. Тэгэхээр энэний хүрээнд саяын тогтоолын хэрэгжилтийг бас хангаад явах боломжууд 4 тэрбум төгрөг сүүний урамшуулалд. Нийтдээ 44.5 гээд бүх урамшууллууд үндсэндээ орж байгаа. Ойролцоогоор 8 нэр төрлийн бүтээгдэхүүний урамшуулал орж байгаа юм.

Тэгээд сүүн дээр 4 тэрбум байгаа гэж. Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хүрээнд олгогдох зээлийн хувьд бид бүхэн арилжааны 10 банкттай хамтарсан гэрээгээ байгуулсан.

Т.Энхтүвшин: Батлут гишүүн.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Шинэ сэргэлтийн бодлого, Аж үйлдвэржилтийн сэргэлттэй холбоотой асуудал хэлэлцэж байна. Тодорхой хэдэн асуулт байгаа юм.

Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж эхэлж байгаа эхэлснээс хойш ямар хууль, эрх зүйн орчныг бид өөрчилснөөрөө ямар дэвшилүүдийг бий болгов? Шинэ сэргэлт буюу аж үйлдвэржилтийн сэргэлт маань ингэснээрээ аж үйлдвэржилтийн сэргэлтэд ямар нөлөөллийг үзүүлэв? Одоо бас аж үйлдвэржилтийн сэргэлт энэ жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчтэй холбоотой ямар ямар асуудлуудыг шийдэх шаардлага байгаа гэж харж байгаа юм? Гадуур ярьж байгаа зүйлүүд одоо үйлдвэр бизнес эрхэлж байгаа, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид ч бай, эрхэлж байгаа энэ хүмүүс дээр маш их дарамт шахалтууд байна, сөхөрч байна л гээд байгаа. Бодит байдалтайгаа нийцэж байгаа юм уу, үгүй юү? Энэ дээр 1 хариулт өгөөч гэж.

Хоёрдугаарт нь бид нар ингээд туйлширдаг зүйлүүд их байгаад байгаа юм л даа. Яах вэ ингээд л жижиг, дунд үйлдвэрлэл дэмжих жил гээд зарладаг. Тэр жил нь 1 жил яваад мартчихдаг. Тэгээд дараа жилээс тэр дэмжиж байгаа үедээ олон сайхан бодлого, шийдвэрүүдийг гаргаад явчихдаг. Дараа жилээс нь яах вэ буцаагаад хүндрүүлээд явчихдаг. Нөгөө шийдвэрүүдээ эргүүлж хардаг ч үгүй юм уу, эсвэл өөрчлөөд явчихдаг. Энэ байдал чинь энэ жижиг, дунд үйлдвэрлэлүүд тогтвортой үйл ажиллагаа явуулах, хөгжих боломжуудыг хязгаарлаад байна. Хязгаарлаад байгаа юм.

Магадгүй ийм шийдэл гаргаж байгаа бол урт удаан хугацааны бодлогыг гаргах ёстой гэж харж байгаа юм. Өнөө жил жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн 53.6% хувь нь бичил бизнес эрхлэгч нар байгаа. Тэгэхээр бичил бизнес эрхлэгчдийг бид нар ямар байдлаар дэмжиж байгаа юм бэ? Тоон судалгаа юу байдаг юм? Хууль, эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох, тэдэнд мэд мэдээлэл хүргэх, төрөөс авах энэ боломжуудыг ашиглах тал дээр Хүнс, хөдөө аж ахуйн яам өөрөө яаж ажиллаж байгаа юм бэ гэдэг тал дээр хариулт өгөөч.

Нэг ёсондоо хөгжингүй орнууд бичил бизнес эрхлэгчдийг маш ихээр дэмждэг. Тэндээс гарч байгаа маш сайн санаа буюу тэр энэ санааг технологийн дэвшлийг ашиглаж цаашилаад жижиг, дунд үйлдвэрлэлүүд болох боломжуудыг нээж өгдөг байгаа. Тэгэхээр энэ тал дээр бид нар ямар ахиц гаргах юм? Ийм жишээ байгаа юм уу бид нарт? Өнөөдөр бид нар зүгээр технологи гэхлээр, энэ аж үйлдвэрийн сэргэлт гэхлээр үндсэндээ хуучин явж байсан ноос, ноолуурын үйлдвэр, махны үйлдвэрээ л яриад байгаа. Хэдэн жил ярив, ямар ч үр дүн гарсан юм мэдэхгүй байна би бас. Тэгээд дэвшил гараад байгаа юм уу, гарахгүй байгаа юм уу?

Тэгвэл Монголчууд бид нар юугаараа дутуу юм бэ? Монголчуудын гаргасан тийм технологийн шийдэл бүхий үйлдвэрүүд байгаа юм уу? Байгаа бол бид яаж дэмжиж байна? Энийгээ ер нь цаашилаад энэ технологи, инновац, тал дээр нь бид нар ямар хөрөнгө оруулалтыг хийх юм, ямар эрх зүйн орчныг боловсронгуй болгох ёстой юм бэ?

Бид дандаа түүхий эдийг нь ч юм уу, технологийг нь гаднаас хуулбарлан авч, суурьшуулах, нутагшуулах ёстой юм уу? Энэ тал дээр яамны бодлого өөрөө юу байгаа юм гэдэг тал дээр хариултууд авъя.

Т.Энхтүвшин: Сайд хариулах уу? Дэд сайдын микрофоныг өгье 1 номер.

М.Ганхүлэг: Батлут гишүүний асуултад хариулъя. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ямар хууль, эрх зүй батлагдаж, ямар үр дүнгүүд гарч байгаа вэ гэдэг асуулт асуулаа.

Би өөрт байгаа мэдээллийн хүрээнд бас танд хариулаад, нэмэлт мэдээллээ бас бичгээр танд бас гаргаж би өгье гэж бодож байна.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд аж үйлдвэрийн тухай дэмжих үндсэндээ хуультай болж авсан бид бүхэн. Үүний хүрээнд томоохон Дархан болон Ховд, Дорнод дээрх энэ төслүүд маань бас явах үндэс сууриуд бий болж байгаа. Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд бас энэхүү тодорхой, тухайн бүс нутагт үйлдвэрлэл эрхлэх энэ боломжуудын бас үр дүнгүүд гараад ирэх суурь эрх зүйн орчнууд бүрдээд ингээд явж байна.

Цаашидаа Хөнгөн үйлдвэрийн энэ хуулийн төслийг боловсруулан бэлтгэх энэ ажлууд дээр бид бүхэн анхаараад ингээд бас ажиллаад явна гэдгийг бас хэлэх байна.

Мөн өнгөрсөн хугацаанд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр батлагдсан Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай ийм бас хуулийн хүрээнд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай тоног, төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл 100% чөлөөлж байгаа. Тэгээд энэ манай бас салбарынхны хувьд нэлээн бас томоохон дэмжлэг болж өгч байгаа. Бусад тийм тоног төхөөрөмж.

Мөн бас өнөөдөр бас яригдаж байгаа тэр малын хорио цээрийн дэглэм бүхий аж ахуйн нэгж, бүс болох энэ чиглэлийн хуулийн төслийн бас энэ чиглэлээр манайхан бас нэмэлтээр бас ажиллаж байна. Бусад би мэдээллүүдийг танд бичгээр гаргаж өгье гэж бодож байна.

Энэ жил жижиг, дунд үйлдвэрлэл талаар бас таны хөндөж байгаа асуудал зөв. Төгтвортой байх тухай энэ талаар бас анхаарах асуудал зөв. Сүүлийн жилүүдэд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сантай холбогдолтой хардалт, сэрдэлт янз бүрийн ийм маргаантай асуудал харьцангуй бас бид бүхэн маш их өндөр хяналттай ажилладаг болсон. Бүх шатдаа нээлттэйгээр шалгаруулалтуудаа хийдэг болсон. Энэ

жилийн хувьд үндсэндээ нэлээн эрт шалгаруулалтаа зарлаад, сайдын тушаал гараад ингээд үндсэндээ шалгаруулалтууд хийгдсэн. Нийтдээ 655 төсөл, арга хэмжээ ирсэн байгаа. Ойролцоогоор 96.6 тэрбум төгрөгийн нийтдээ төсөл байна.

Бид бүхний боломж бол өмнөх жилүүдийн жижиг дундын зээлүүдийг авсан аж ахуй нэгжүүд маань буцаан төвлөрүүлэх байдлаар эх үүсвэрээ гаргаж байгаа. Тэгэхээр үнэндээ үндэслээд бид бүхэн ойролцоогоор 30 тэрбум төгрөгийн зээлийг энэ жил бас олгохоор үндсэндээ тооцсон байгаа.

Тэгэхээр энэ 655 аж ахуйн нэгжээсээ шаардлага хангасан аж ахуй нэгжүүддээ олон нийтэд нээлттэй, ил тодоор, үндсэндээ төслүүдийг нь шалгаруулаад, энэ жилийн хувьд 30 тэрбумын дэмжлэгийг үзүүлээд ингээд явна.

Цаашидаа бас илүү бие даасан энэ сангийн үйл ажиллагааг бас нэмэгдүүлэх энэ чиглэл дээр анхаарах нь зөв гэдэг дээр тантай санал нэг байна.

Мөн нийт төслийн 0-100 сая хүртэлх төсөл нь одоо үндсэндээ 421 буюу дийлэнх төсөл нь байгаа. Тэгэхээр яг үндсэндээ яг энэ 100 сая хүртэлх ийм төсөл, саналууд ирүүлж байгаа аж ахуйн нэгжийн 64.3%-ийг эзэлж байгаа. Энэ чиглэлийн ажлууд бас манай яам дээр хийгдээд явж байна.

Т.Энхтүвшин: *Болсон уу Батлут гишүүн? Технологийн шийдэлтэй холбоотой асуудал дээр Дондогдорж дарга. Тийм үү? Аж үйлдвэрийн сэргэлт хүнс, хөдөө аж ахуйн. Нэмэлт байгаа юм уу? Батлут гишүүн тодруулъя. Тодруулъя.*

Д.Батлут: *Би асуултаа асуудаг нь илүүтэй тийм технологийн шийдлийг Монголчууд өөрсдөө гаргадаг болоосой гэж хүсэж байгаа юм. Энэ бол одоо бидний хөгжлийн хамгийн том шийдэл.*

Тийм шинжлэх ухааны байгууллагуудтай хамтарсан технологийн шийдлийг бий болгодог, түүнийгээ ингээд үйлдвэрлэлд илжжүүлдэг, цаашилаад ингээд дэлхийд гаргадаг ч юм уу тийм ээ? Энэ байдал дээр манай Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан юу хийж байгаа юм бол гэдэг асуулт асуусан байхгүй юу.

Яг үнэндээ өнөөдөр бид нар хуучин л ярьдаг мах, сүү, ноос, ноолуур, хуучин нөгөө энд тэндээс авсан технологи, тэр шийдэл нь өнөөдөр нутагшчихсан явж байгаа. Түүнийгээ яаж өргөжүүлж байгаа тухай л яриад байна бид нар. Яаж зээл олгож байгаа юм гээд л.

Тэгвэл бичил бизнес эрхлэгч нар дээр бид нар ямар бодлого барьж байгаа юм? Яг цэвэр Монголчуудын өөрсдийн гаргасан тэр идея-г хөгжүүлэх тал дээр бид нар ямар бодлого гаргаж ирж ажиллаад байгаа юм бэ? Цаашилаад ер нь бичил бизнес гэдэг зүйлийг бид яаж дэмжих юм? Өнөөдөр тэр гаалийн татвар гээд байна шүү дээ тийм үү? Чөлөөлж байгаа гээд. Энд тэр чинь орж байгаа юм уу? НӨАТ-аа яах юм? Бид нар.../минут дуусав./

Т.Энхтүвшин: 1 номер дэд сайд хариулья.

М.Ганхүлэг: Яг чиг үүргийн хүрээнд бас хүнс, хөдөө аж ахуйн салбарын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийг бас миний бие бас хариуцан ажилладаг. Тэгээд таны бас дэвшүүлж байгаа саналтай би бас санал нэг байна.

Тулгамдаж байгаа хэд хэдэн бас асуудлууд байгаа. Бүх хүрээлэнгүүд дээрээ нэлээн тулж бас ажилласан. Хэд хэдэн шинжлэх ухааны зөвлөлийн хурал, уулзалтуудаа бас зохион байгуулсан. Ингэж шинэчилье гэдэг нэртэй инновацын бас төслийн уралдаан энэ тэр гээд зарласан. Ингээд өөрсдийнхөө хэмжээндээ бас тодорхой хөтөлбөр, арга хэмжээнүүд хэрэгжүүлээд ажиллаж байгаа.

Гэхдээ манай салбарын 4 хүрээлэн байгаа. Манай салбарын Ургамал хамгааллын, Мал аж ахуйн ингээд яг чиглэл чиглэлийн хүрээлэнгүүд маань үндсэндээ яг одоо Боловсролын яамны харьяа байж байдаг. Яг манай Мал аж ахуйн газар болон бусад газруудтайгаа бас хоорондын хамтын ажиллагаа юмнууд дээр нэлээн асуудлууд байгаа юм байна гэдгийг би бас очиж уулзахдаа анзаарсан.

Хоёр дахь нь болохоор жилдээ шалгаруулдаг тэр төсөл, арга хэмжээний тэр санхүүжилтийн дүн нь хязгаартай. Хамгийн ихдээ 1-2 төслийг л. Тэгээд тэр нь нэг ойролцоогоор 150-200 сая төгрөгийн энэ төслүүдийг шалгаруулаад.../минут дуусав./

Т.Энхтүвшин: Шинэ сэргэлтийн бодлого, Аж үйлдвэрийн сэргэлтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайдын мэдээлэлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Санал авъя. Батлут гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ Шинэ сэргэлтийн бодлоготой холбогдуулж энэ аж үйлдвэрийн сэргэлтийнхээ асуудлыг бид онцгой анхаарах ёстой. Тэр тусмаа бэлэн нөөцүүд дээрээ тулгуурлаж, тэр нөөцийг зохистой ашиглах, үйлдвэрлэл болгох, баялаг болгох тал дээр бодлогуудаа илүү нарийсгаж гаргамаар байна. Энэ нь бидэнд үнэхээрийн хэрэгтэй байгаад байгаа зүйл.

Ноолуурын бодлого чиглэл тэгээд нэг ийм зохистой юм руугаа ерөнхийдөө явах хандлага нь бий болж байна гэж ингэж ойлгож байна. Тийм учраас тодорхой хугацаануудад боловсруулалтын түвшинийг нь ахиулах бодлогоо хэдүүлээ түрээд түрээд яваад байвал энэ гайгүй болно. Би бол хялгас ялгах боловсруулалтын түвшинээс ээрэх түвшин рүүгээ явах юмаа л хэдүүлээ хийх

ёстой. Ингэж л бодлогоо барьж чадвал гэж.

Дараагийн биднүүст нэлээн том боломж бол би наад ноосон дээр чинь байгаа юм. Тэр бутархай гэдэг юм уу, зунгагтай ноосоо тэр бордоо руугаа өгчхөөд, бусад нарийн ноосоо тэр хивс рүүгээ өгчхөөд, бүдүүн ноосоо угаагаад, самнаад тэр ноолуурлаг буюу тэр 18-24 орчим микронтой гараад байгаа тэр хэсгээ ялгаж аваад, гадаад зах зээл рүү гаргадаг гэдэг юм уу, дотоодын бүс, барааны үйлдвэрлэлийнхээ түвшин рүү ашигладаг гэдэг юм уу энэ юмаа хийгээд, тэндээсээ гарсан хялгастай хэсгээрээ дулаалга гэдэг юм уу, эсгийгээ хийдэг, эсгий гутлаа хийдэг энэ түвшин рүүгээ явчихвал бидэнд нэлээн тийм том боломж үүсэх юм. Энэ талаас нь би бодлого юмнуудаа илүүтэй харах ёстой болов уу гэсэн нэг ийм зүйл байгаад байгаа юм.

Дараа нь энэ газар тариалангийн бүтээгдэхүүнүүд дотроос боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох ёстой хэд хэдэн гол зүйл байх шиг байна. Тэр дотор наад төмс боловсруулдаг технологийн талын юмыг хэдүүлээ нэлээн нарийн гаргаж ирж чадах юм бол бидэнд маш том боломж, нөөц байгаад байгаа юм. Бид хэдий хэмжээний цардуул гаднаас аваад байгаа билээ. Яаж энэ цардуулын үйлдвэрийг дотооддоо бий болгох вэ. Энэ нэг түлш гээд нэг юм яриад, барьцалдуулагч гэдэг юмны учрыг ололгүй 2, 3 жил болоод анхны хийж байсан түлш одоогийн түлш хоёрын хооронд бас асуудал байна гэдэг юм яригдаад байгаа шүү дээ улсууд, хэрэглэж байгаа улс нь.

Тэгэхээр зэрэг үүнийгээ яаж хангаж болох юм, энэ хангалт нь энэ төмс боловсруулалт дээрээ тулгуурлаж гарах ёстой юм биш үү гээд үйлдвэр хоорондын технологийн кластер хоршилтууд хийгдэх ийм бололцоо боломж байгаад байгаа юм байна гэж ингэж харагдах жишээтэй.

Дээр нь энэ сүүний үйлдвэрүүд дээр биднүүс хуурай сүүний үйлдвэрийг яах юм. Тэртээ тэргүй бид энэ зайрмагийн гэдэг юм уу, янз бүрийн технологийнхоо шаардлагаар хуурай сүү хэрэглэдэг үйлдвэрлэлийн технологитой үйлдвэрүүд байгаад байна шүү дээ. Үүнийгээ хэдүүлээ яаж хангах юм бэ? Яаж үүнийг хэдүүлээ бас энэ шингэн сүү нийлүүлэлтийн асуудалд нь их учиргүй хүндрэл учруулчихгүй сүүний нөөцтэй, улирлын шинж чанартай бүс нутгуудад ийм жижиг үйлдвэрүүд байгуулах замаар үүнийг хийж болох юм уу гэж.

Үндсэндээ хадгалалтын цаг хугацаа дааж чаддаг тийм бүтээгдэхүүн болгох л тухай асуудал байна шүү дээ. Тодорхой зах зээлээс алслагдсан сүүний нөөцийг ашиглая л гэж бодвол биднүүс яах аргагүй тийм л үйлдвэрийн тухай л асуудал яригдаад байгаа юм.

Жишээ нь, хуурай сүүнийхээ асуудлыг яах юм? Тэгэх юм бол импортын хуурай сүүг хаах нэлээн том боломж байна гээд. Яг энэ мэтчилнээр биднүүс энэ үйлдвэрийнхээ бодлого, энэ юмнуудаа их тодорхой гаргаж ирээд тэгээд тэрэндээ төрийн бодлого, дэмжлэг, санхүүгийн механизм энэ бүх юм нь цогцоороо тогтвортой чиглүүлж чадах юм бол тодорхой хугацааны ар дээр биднүүсийн яриад байгаа ёстой өнөө аж үйлдвэрийн сэргэлт буюу дотоодынхоо хэрэгцээг дотоодоосоо хангах, үйлдвэрлэгч, экспортлогч орон болох том зорилтын эхлэлийг хангахад нэлээн тийм том боломж бий болох юм байна гэж ингэж харж байгаа.

Тийм учраас энэ талаасаа бүх хөдөө аж ахуйн ашиг шим, түүхий эдүүд дээрээ тулгуурлаж нөөцийг зохистой ашиглах, боловсруулах, үйлдвэрлэл болгох, буцаагаад зах зээлд борлуулах, түүнд үзүүлэх дэмжлэгийн асуудлыг л бид онцгой бодох ёстой. Ер нь энэ цогцоороо л дэмжигдэх юм байна. Энэ дээр л хэдүүлээ анхаарч л байх хэрэгтэй байна. Энийг бид

та бүгдийг анхааралдаа аваач гэж хүсэж байна.

Т.Энхтүвшин: Батлут гишүүн.

Д.Батлут: Аж үйлдвэржилтийн сэргэлт гээд аваад ингээд ярингуут 80 онд байсан, 90 онд байсан бүх төрөл яг одоо л яг ингээд л яваад л давхар хамт л явж байна. Илүү яг төрөлжиж олон болсон зүйл үндсэндээ алга. Тэгээд л арьс ширний үйлдвэр, ноос ноолуурын үйлдвэр, махны үйлдвэр, одоо тэгээд өөр юу нэмэгдсэн юм? Оёдол гэж, мужсаан гээд л тээ байдаг л хэдэн зүйл.

Өөр хэрэгцээ, шаардлагуудыг бид нар зөв тодорхойлж гаргаж ирээд, түүн рүү чиглэсэн бодлогуудыг бас гаргаж өгмөөр байгаа юм. Бодлогуудыг гаргаж өгмөөр байгаа юм. Нэг ёсондоо шинжлэх ухааныхаа байгууллагуудтай нягт уялдаа холбоотой ажиллаж, тэр дундаа энэ бичил бизнес эрхлэгчдийг дэмжих урт хугацааны бодлогыг гаргаж, түүн дээр томоохон эрх зүйн орчныг нь боловсронгуй болгож, хөгжүүлэх тал дээр анхаараач гэж.

Өнөөдөр бид нар аж үйлдвэрлэлийн парк гээд том том юм яриад байгаа хэдэн жил ярив, өнөөдөр ямар үр дүн өгөв гэж харж байна. Харин бичил бизнес эрхлэгчдээ бид нар дэмжих юм бол маш богино хугацаанд үр дүн гарах боломжтой болж байгаа. Маш богино хугацаанд шүү. Дор хаяж бид нар энэ бичил бизнес эрхлэгчдийн тоног төхөөрөмжийг хил, гаалийн татвараас чөлөөлдөг, тэр НӨАТ-аас нь чөлөөлдөг, урт удаан хугацаанд энэ чөлөөлөх арга хэмжээ аваад бизнес эрхлэгчдийг орон нутгийнх нь онцлогт тохируулсан байдлаар тэргүүлэх чиглэлийг нь тодорхойлоод хөгжүүлдэг тэр загварчлал руу орж өгөх хэрэгтэй.

Тэр дундаас нь бас яг үнэхээр технологийн шаардлага хангахуйц тэр бизнесүүдийг илүү жижиг, дунд хэлбэр лүү нь түлхэж өгдөг байх хэрэгтэй.

Ингээж байж энэ олон төрөл энэ аж үйлдвэржилтийн салбар чинь хөгжих, хөгжихдөө бүүр олон төрлөөр хөгжих боломж бололцоо гарч ирнэ гэж харж байна.

Тэгэхгүй өнөөдөр бид гарын 5 хуруунд эргэлдүүлдэг хэдэн салбараа л яриад байдаг. Чиглэлээ л яриад байдаг байж болохгүй шүү дээ. Ингээж байж цаашаа аж үйлдвэржилтийн сэргэлт маань үндсэндээ дээд, доод бүхий л түвшинд хөгжих, түүнээс улбаалсан олон үр дүнгүүд гарах. Татварын болоод хүний нөөцийн, ажиллах хүчний, ажилгүйдлийг багасгах олон үр дүнгүүд гарна.

Ний нуугүй ярихад өнөөдөр бичил бизнес эрхлэгчдээ дэмжих дэмжлэг төрөөс ямар байгаа юм болдоо. Хараад, судлаад, үзээрэй. Би бол судалж байгаа. Өнөөдөр бид нар бизнес эрхлэгчдээ зөв томёолохоос авхуулаад л эхэлнэ. Бичил бизнес эрхлэгч гэж хэнийг хэлэх юм бэ? Ямар эргэлтийн хөрөнгөтэй хүнийг хэлэх юм. Амьдрал дээр. Тэд нарт ямар эрх зүйн орчин шаардлагатай байгаа юм. Тэр хүмүүс өөрөө өөртөө ажлын байр гаргана. Өрөө л хэн нэгэнд ажлын байр гаргах гэж явж байгаа хүмүүс. Банкин дээр очихоор шалгуур үзүүлэлтүүд хангадаггүй. Тэндээс нэг зээл олчих л юм бол ямар нэгэн байдлаар ажиллачих гээд, шинэ гоё санаанууд гаргачих гээд яваад байгаа хүмүүс зөндөө байгаа.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн 53.6% нь бичил бизнес эрхлэгч нар байгаа шүү. Тэд нар нь хэд нь одоо ажиллаж байгаа юм? Магадгүй цаана нь бас түүнээс илүү олон хүмүүс бизнес эрхлэх санаатай, хөгжүүлэх гээд ингээд яах учраа олохгүй явж байгаад олон хүмүүс байгаа.

Тийм учраас бид нарыг хөрс, сууриа зөв тодорхойлоод, түүн рүү чиглэсэн бодлогын зөв шийдлүүдийг гаргаад, урт удаан хугацаанд хэрэгжих боломжуудыг гаргаж өгөх хэрэгтэй. Түрүүний миний дурдсанчлан бүс нутгийн онцлогтоо

тохируулах хэрэгтэй, татвар, чөлөөт хөнгөлөлтийн томоохон бодлогыг урт удаан хугацаанд тавьж өгөх хэрэгтэй. Тэгээд төрөлжүүлж өгөх хэрэгтэй. Инновац шингэсэн цаашаа хөгжих боломжтой олон үйлдвэрлэлүүдийг жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх тал дээр бодлогоор дэмжиж өгдөг байх хэрэгтэй.

Шинжлэх ухааны байгууллагуудтай хамтарч ажиллах хэрэгтэй, технологийн шийдлүүдийг өөрсдийн шийдлүүдийг гаргадаг байх хэрэгтэй гээд ингэж цогцоор нь харж ажиллаж байж аж үйлдвэржилтийн бодлого маань хэрэгжиж, ажилгүй хүмүүсийн тоо багасаж нөгөө халамжаас хөдөлмөрт шилжих процесс маань илүү үр дүнтэй, нүдэнд харагдахуйц үр дүнтэй явна гэж харж байгаа.

Би том төслүүдийг үгүйсгээгүй ерөөсөө. Хэрэгжих шаардлагатай юу? Шаардлагатай, цаг хугацаа их авна. Хэдэн жил ярьж байна та бүхэн хараарай, Аж үйлдвэрийн парк байгуулна гээд ярьж байгаа. Өнөөдөр хүртэл гацаатай байгаа Дарханы арьс ширийн үйлдвэр гээд л бодоод үз. Тэр дор жижиг, дунд үйлдвэрлэл чинь дийлэнх олонхыг хамаараад байгаа тэр бичил бизнес эрхлэгчдээ бид нар бодлогыг нь зөв болгоод, жоохон хөнгөлөлт эдлүүлээд, боломжийг нь гаргаад өгчих юм бол маш хурдан сэргэлт, маш томоохон үр дүнг гаргаад эхэлнэ шүү. Богино хугацаанд. Үүн дээр бас манай Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан илүү анхаарч ажиллаач гэж хүсмээр байгаа юм. Баярлалаа.

Т.Энхтүвшин: Би ганц, хоёр асуудал тавья. Үйлдвэр технологийн паркийн тухай хууль батлагдсан нэмэлт өөрчлөлт хийгээд. 2022 оны 8 сарын 1-нээс эхлээд үйлдвэр, технологийн парк бас хэрэгжээд явж байгаа. Одоо нөгөө хөдөө аж ахуйн үйлдвэр технологийн парк нь хаана байх ёстой юм? Хөнгөн үйлдвэрлэлийн үйлдвэр, технологийн парк нь хаана байх ёстой гэдэг юмнуудаа бас

тодорхойлоод Засгийн газрын хэмжээнд зарлах хэрэгтэй байна.

Ховд үйлдвэр, технологийн парк гээд зарлагдсан. Дарханы арьс ширний үйлдвэр технологийн парк гээд зарлагдсан байж байгаа. Одоо тэгээд Дорнод үйлдвэр, технологийн парк ч гэдэг юм уу энэ юмнуудаа яаралтай зарлаад явах хэрэгтэй байна гэдгээ хэлмээр байна.

Дараагийн асуудал яах аргагүй энэ Дарханы арьс ширний үйлдвэрийн маргаантай асуудал нэг талдаа гаргаж шийдэгдсэн байна гэж ойлголоо. Тэгээд үүн дээрээ бас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам өөрөө нэлээн ач холбогдол өгч, гүйцэтгэлд нь бас хяналт тавьж яваарай гэж хүсмээр байж байна.

Гурав дахь асуудал дээр юу байна вэ гэхээр бид нар Хүнд үйлдвэрлэлийн тухай хууль, Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийг олон жил ярилаа. Ер нь сая дэд сайдын мэдээлэлтэй холбогдуулаад тантай бас санал нэг байж байна. Ер нь Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хууль, Хүнд үйлдвэрлэлийн тухай хуулиа нэгтгээд Аж үйлдвэрийн тухай хууль гээд ер нь нэгтгээд хийгээд явбал яасан юм бэ? Ер нь тэгээд доторх бичсэн зүйлүүд нь ч гэсэн нэг форматаар, томъёолол нь ч гэсэн бас нэлээн ойролцоо хууль байна лээ.

Тийм учраас Аж үйлдвэрийн тухай хууль гээд хийгээд явбал яасан юм? Та хэд маань Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яамтайгаа уулзаад байр сууриа бас хоорондоо солилцоод, ингээд ер нь аж үйлдвэрийн сэргэлтийн энэ хүрээндээ Аж үйлдвэрийн тухай хууль гээд ер нь нэгтгээд, ингээд ажлын хэсэг гаргаад тэгээд энэ чуулганаар ороод ингээд явбал их зөв байх гэсэн ийм бодолтой байна.

Ингээд энэ удаагийн Аж үйлдвэрийн сэргэлт Хүнс, хөдөө аж ахуйн яамны мэдээллийг сонсож дууслаа.

Хуралд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийн

*хамт олондоо бас баярлалаа. Хурал
хаасныг мэдэгдье.*

15.58 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*